

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Говьсүмбэр аймгийн Нийтийн номын сан”-гийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/53/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: С.Батцэцэг Утас:70543179 Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2022.02.24 № 04

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Нийтийн номын сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Нийтийн номын сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020019

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
№	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,310,429	16,368,691
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,941,253	1,850,780
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,941,253	1,850,780
4	Төгрөг	1,941,253	1,850,780
5	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,941,253	1,850,780
6	АВЛАГА		2,500,000
7	Бусад авлага		2,500,000
8	Байгууллагаас авах авлага		2,500,000
9	БАРАА МАТЕРИАЛ	11,369,176	12,017,911
10	Хангамжийн материал	11,369,176	12,017,911
11	Бичиг хэргийн материал	1,655,100	1,951,680
12	Аж ахуйн материал	9,714,076	10,066,231
13	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	489,617,665.74	478,638,820.77
14	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	489,617,665.74	478,638,820.77
15	Биет хөрөнгө	481,805,665.76	473,402,820.83
16	Барилга, байгууламж, орон сууц	382,722,187.46	382,722,187.46
17	Хуримтлагдсан элэгдэл	-13,747,995.36	-20,621,993.04
18	Авто-тээврийн хэрэгсэл	5,350,000	5,350,000
19	Хуримтлагдсан элэгдэл		-1,783,333.32
20	Машин тоног төхөөрөмж(компьютер)	15,268,407.95	16,518,407.95
21	Хуримтлагдсан элэгдэл	-5,877,741.09	-9,499,490.25
22	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,483,927.55	16,483,927.55
23	Хуримтлагдсан элэгдэл	-13,462,385.75	-14,655,995.52
24	Ном	95,069,265	98,889,110
25	Биет бус хөрөнгө	7,811,999.98	5,235,999.94
26	Програм хангамж	2,974,200	2,974,200
27	Хуримтлагдсан элэгдэл	-2,722,200.02	-2,778,200.06
28	Бусад биет бус хөрөнгө	7,560,000	5,040,000
29	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	502,928,094.74	495,007,511.77
30	НИЙТ ӨР ТӨЛБӨР	639,165	
31	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	639,165	
32	Өглөг	639,165	
33	Ажилчидтай холбогдсон өглөг	639,165	
34	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	502,288,929.74	495,007,511.77
35	Засгийн газрын хувь оролцоо	502,288,929.74	495,007,511.77
36	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	63,834,850.34	61,314,850.34
37	Хуримтлагдсан үр дүн	297,056,621.48	292,295,203.51
38	Өмнөх үеийн үр дүн	295,202,314.26	297,056,621.48
39	Тайлант үеийн үр дүн	1,854,307.22	-4,761,417.97
40	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	141,397,457.92	141,397,457.92
41	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	502,928,094.74	495,007,511.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/ төгрөгөөр /	
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	159,287,230	150,585,155	
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,527,930	11,543,655	
3	Нийтлэг татварын бус орлого	11,527,930	11,543,655	
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,540,853	658,510	
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,540,853	658,510	
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,987,077	10,885,145	
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,759,300	139,041,500	
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,004,200	1,250,000	
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,470,000	1,250,000	
10	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	534,200		
11	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,755,100	137,791,500	
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,755,100	137,791,500	
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	157,432,922.78	155,346,572.97	
14	УРСГАЛ ЗАРДАЛ	157,432,922.78	145,358,572.97	
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,513,872.25	141,919,759.24	
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,248,420.47	103,143,535	
17	Үндсэн цалин	104,248,420.47	76,266,754	
18	Нэмэгдэл		21,828,301	
19	Унаа хоолны хөнгөлөлт		5,048,480	
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,248,910.23	13,103,083.27	
21	Тэтгэврийн даатгал	9,612,334.43	9,535,991.21	
22	Тэтгэмжийн даатгал	1,115,364.55	1,058,450.97	
23	ҮОМШӨ-ний даатгал	831,809.04	819,878.53	
24	Ажилгүйдлийн даатгал	165,556.49	153,523.6	
25	Эрүүл мэндийн даатгал	1,523,845.72	1,535,238.96	
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,673,540.77	6,516,557	
27	Гэрэл, цахилгаан	1,222,483.77	1,073,579	
28	Түлш, халаалт	5,641,595	5,381,266	
29	Цэвэр, бохир ус	559,462	61,712	
30	Байрны түрээс	250,000		
31	Хангамж, бараа материалын зардал	7,914,505	3,418,156	
32	Бичиг хэрэг	2,634,100	1,259,612	
33	Тээвэр, шатахуун	546,000	364,000	
34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,447,000	937,494	
35	Ном, хэвлэл	90,500	36,000	
36	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	125,000	211,000	
37	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,071,905	610,050	
38	Нормативт зардал	2,550,000		
39	Хоол, хүнс	2,550,000		
40	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000	40,000	
41	Багаж, техник, хэрэгсэл	100,000		
42	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		40,000	
43	Томилолт, зочны зардал	839,600	120,700	

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

44	Дотоод албан томилолт	839,600	120,700
45	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,877,500	743,650
46	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,470,000	20,208
47	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000	
48	Даатгалын үйлчилгээ	247,500	247,500
49	Тээврийн хэрэгслийн татвар	49,500	49,500
50	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000	33,000
51	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	313,500	388,630
52	Газрын төлбөр		4,812
53	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,000	
54	Бараа үйлчилгээний бусад зардал	14,061,395.78	14,834,077.97
55	Бараа үйлчилгээний бусад зардал	2,687,500	1,305,388
56	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,373,895.78	13,528,689.97
57	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,919,050.53	3,438,813.73
58	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000	1,665,617
59	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000	1,665,617
60	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,419,050.53	1,773,196.73
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,419,050.53	1,773,196.73
62	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		9,988,000
63	Дотоод эх үүсвэрээр		9,988,000
64	Их засвар		9,988,000
65	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,854,307.22	-4,761,417.97
66	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,854,307.22	-4,761,417.97

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,834,850.34	133,515,666.32	295,202,314.26	492,552,830.92
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,834,850.34	133,515,666.32	295,202,314.26	492,552,830.92
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		7,881,791.6		7,881,791.6
4	Тайлант үеийн үр дүн			1,854,307.22	1,854,307.22
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,834,850.34	141,397,457.92	297,056,621.48	502,288,929.74
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	63,834,850.34	141,397,457.92	297,056,621.48	502,288,929.74
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,834,850.34	141,397,457.92	297,056,621.48	502,288,929.74
8	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-2,520,000			-2,520,000
9	Тайлант үеийн үр дүн			-4,761,417.97	-4,761,417.97
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	61,314,850.34	141,397,457.92	292,295,203.51	495,007,511.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	151,300,153	139,700,010
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,540,853	658,510
3	Нийтлэг татварын бус орлого	3,540,853	658,510
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,540,853	658,510
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,540,853	658,510
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,759,300	139,041,500
7	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,004,200	1,250,000
8	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,470,000	1,250,000
9	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	534,200	
10	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,755,100	137,791,500
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,755,100	137,791,500
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	144,646,400	135,617,783
13	УРСГАЛ ЗАРДАЛ	144,646,400	135,617,783
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,727,349.47	132,178,969.27
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	103,335,594.47	103,782,700
16	Үндсэн цалин	91,739,758.27	76,905,919
17	Нэмэгдэл	10,470,837.2	21,828,301
18	Унаа хоолны хөнгөлөлт	1,124,999	5,048,480
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,248,914.23	13,103,083.27
20	Тэтгэврийн даатгал	9,480,604.01	9,535,992.69
21	Тэтгэмжийн даатгал	1,115,366.06	1,058,450.44
22	ҮОМШӨ-ний даатгал	831,809.39	819,878.89
23	Ажилгүйдлийн даатгал	165,557.06	153,523.35
24	Эрүүл мэндийн даатгал	1,655,577.71	1,535,237.9
25	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,688,540.77	6,516,557
26	Гэрэл, цахилгаан	1,237,483.77	1,073,579
27	Түлш, халаалт	5,641,595	5,381,266
28	Цэвэр, бохир ус	559,462	61,712
29	Байрны түрээс	250,000	
30	Хангамж, бараа материалын зардал	4,509,700	3,049,094
31	Бичиг хэрэг	2,010,000	1,250,000
32	Тээвэр, шатахуун	546,000	364,000
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,473,500	1,188,094
34	Ном, хэвлэл	64,000	36,000
35	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	416,200	211,000
36	Нормативт зардал	3,210,000	727,150
37	Хоол, хүнс	2,550,000	
38	Нормын хувцас, зөөлөн эдлэл	660,000	727,150
39	Эд хогшил, урсгал засварын зардал	2,330,000	2,964,000
40	Багаж, техник, хэрэгсэл	1,030,000	2,500,000
41	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000	464,000
42	Урсгал засвар	1,000,000	
43	Томилолт, зочны зардал	839,600	120,700

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

44	Дотоод албан томилолт	839,600	120,700
45	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,877,500	916,742
46	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,470,000	193,300
47	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000	
48	Даатгалын үйлчилгээ	247,500	247,500
49	Тээврийн хэрэгслийн татвар	49,500	49,500
50	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000	33,000
51	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	313,500	388,630
52	Газрын төлбөр		4,812
53	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,000	
54	Бараа үйлчилгээний бусад зардал	2,687,500	998,943
55	Бараа үйлчилгээний бусад зардал	2,687,500	998,943
56	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,919,050.53	3,438,813.73
57	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000	1,665,617
58	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000	1,665,617
59	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,419,050.53	1,773,196.73
60	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,419,050.53	1,773,196.73
61	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,653,753	4,082,227
62	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,712,500	4,172,700
63	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,712,500	4,172,700
64	Дотоод эх үүсвэрээр	4,712,500	4,172,700
65	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,712,500	4,172,700
66	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,712,500	-4,172,700
67	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,941,253	-90,473
68	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,941,253
69	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,941,253	1,850,780

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	137,791,500	136,018,303.27	1,773,196.73
2	УРСГАЛ ЗАРДАЛ	137,791,500	136,018,303.27	1,773,196.73
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,125,800	134,352,686.27	1,773,196.73
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	103,782,700	103,782,700	0
5	Үндсэн цалин	79,285,800	76,905,919	2,379,881
6	Нэмэгдэл	17,561,900	21,828,301	-4,266,401
7	Унаа хоолны хөнгөлөлт	6,935,000	5,048,480	1,886,520
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,095,100	13,103,083.27	992,016.73
9	Тэтгэврийн даатгал	9,918,700	9,535,992.69	382,707.31
10	Тэтгэмжийн даатгал	1,044,100	1,058,450.44	-14,350.44
11	ҮОМШӨ-ний даатгал	835,300	819,878.89	15,421.11
12	Ажилгүйдлийн даатгал	208,800	153,523.35	55,276.65
13	Эрүүл мэндийн даатгал	2,088,200	1,535,237.9	552,962.10
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,019,900	6,516,557	503,343
15	Гэрэл, цахилгаан	1,321,000	1,073,579	247,421
16	Түлш, халаалт	5,497,000	5,381,266	115,734
17	Цэвэр, бохир ус	201,900	61,712	140,188
18	Хангамж, бараа материалын зардал	6,157,800	5,971,794	186,006
19	Бичиг хэрэг	1,250,000	1,250,000	0
20	Тээвэр, шатахуун	364,000	364,000	0
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,416,000	1,230,094	185,906
22	Ном, хэвлэл	2,916,700	2,916,700	
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	211,100	211,000	100
24	Нормативт зардал	727,500	727,150	350
25	Нормын хувцас, зөөлөн эдлэл	727,500	727,150	350
26	Эд хогшил, урсгал засварын зардал	2,964,000	2,964,000	
27	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000	2,500,000	
28	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	464,000	464,000	
29	Томилолт, зочны зардал	120,700	120,700	
30	Дотоод албан томилолт	120,700	120,700	
31	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,100	916,742	91,358
32	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,300	193,300	0
33	Даатгалын үйлчилгээ	247,500	247,500	
34	Тээврийн хэрэгслийн татвар	49,500	49,500	
35	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000	33,000	
36	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	469,800	388,630	81,170
37	Газрын төлбөр	15,000	4,812	10,188
38	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000	249,960	40
39	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000	249,960	40
40	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,665,700	1,665,617	83

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41	Бусад урсгал шилжүүлэг	1,665,700	1,665,617	83
42	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,665,700	1,665,617	83
43	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	137,791,500	136,018,303.27	1,773,196.73
46	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	137,791,500	136,018,303.27	1,773,196.73
47	Орон нутгийн төсвөөс	137,791,500	136,018,303.27	1,773,196.73
48	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	21	21	
49	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
50	Төсвийн байгууллага	1	1	
51	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	10	
52	Удирдах ажилтан	1	1	
53	Гүйцэтгэх ажилтан	6	6	
54	Үйлчлэх ажилтан	3	3	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,250,000	(1,250,000)
3	УРСГАЛ ЗАРДАЛ		1,250,000	(1,250,000)
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,250,000	(1,250,000)
5	Эд хогшил, урсгал засварын зардал		1,250,000	(1,250,000)
6	Багаж, техник, хэрэгсэл		1,250,000	(1,250,000)
7	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,250,000	(1,250,000)
8	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,250,000	(1,250,000)
9	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,250,000	(1,250,000)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан”-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан”-гийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” нь орон нутгийн иргэд хүүхэд залуусыг ном хэвлэл, мэдээллээр хангах, тэдний мэдлэг хэрэгцээнд зориулсан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төрийн үйлчилгээний соёлын байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “нийт зардал” сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний 159,287.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,592.9 төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1,194.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан”-гийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,920.6 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, хуримтлагдсан үр дүнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,941.2	1,850.8	-90.4
Авлага	0.0	2,500.0	2,500.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	11,369.2	12,017.9	648.7
Үндсэн хөрөнгө	489,617.7	478,638.8	-10,978.9
Нийт хөрөнгө	502,928.1	495,007.5	-7,920.6
Өр төлбөр	639.2	0.0	-639.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	63,834.8	61,314.8	-2,520.0

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хуримтлагдсан үр дүн	297,056.6	292,295.2	-4,761.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	141,397.5	141,397.5	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	502,928.1	495,007.5	-7,920.6

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,850.8 мянган төгрөг нь ахмадын сангийн дансны үлдэгдэл байна. Энэ нь байгууллага мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайландаа үнэн зөв тусгаж тайлагнасан байна.

Авлагын дансны үлдэгдэл нь 2,500.0 мянган төгрөг нь үндсэн хөрөнгө болох ном ариутгах төхөөрөмж худалдан авахаар "Боржигин нутгийн зураг" ХХК-тай гэрээ байгуулж 10 дугаар сард захиалсан боловч хил хаагдсантай холбоотойгоор гэрээний хугацаанд хүлээн аваагүй учраас авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,017.9 мянган төгрөг болж 648.7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 296.6 мянган төгрөг, аж ахуйн материал 352.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 478,638.8 мянган төгрөг болж 10,798.9 мянган төгрөгөөр буурсан нь газар эзэмших гэрчилгээ данснаас хассан мөн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь нийт 5,069.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: машин тоног төхөөрөмжийн данс 1,250.0 мянга, номын фонд данс худалдан авсан 2,922.7 мянга, иргэдийн хандиваар ном 897.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Сүмбэр сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн №А/194 дүгээр захирамжийн дагуу 2 жил ашиглаагүй газар эзэмшлийн гэрчилгээг хүчингүй болгосон байна.

Өр төлбөр дансанд эхний үлдэгдэл болох 639.2 мянган төгрөгийн цалингийн өглөгийг барагдуулж, үлдэгдэлгүй болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 61,314.8 мянган төгрөг болж 2,520.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үед газрын эзэмшлийн гэрчилгээг данснаас хассанаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 292,295.2 мянган төгрөг болж 4,761.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үед зардал өссөнөөс шалтгаалжээ.

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан”-гийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8,702.1 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс туслах үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилт, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 2,086.3 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ, тогтмол зардал, хангамж, бараа материалыг зардал,

нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал зэрэг зардлууд хасагдсан холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлттэй холбоотой залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 235,773.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 235,773.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 97,981.8 мянган төгрөгөөр бууруулж 137,791.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс их хэмжээгээр бууруулж баталсан нь цалин хөлс, тогтмол зардал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг өмнөх оноос нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71702 /Соёл урлаг/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 137,791.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 137,791.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 137,791.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 136,018.3 мянган төгрөгийг зарцуулж, 1,773.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 136,018.3 мянга буюу 98.7 хувьтай байгаа нь НДШ зардлаас 992.0 мянга, тогтмол зардлаас 503.3 мянга, шуудан холбоо, интернэтийн төлбөрөөс 185.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 91.3 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71702 хөтөлбөрийн 1 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 1,773.2 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Соёлын яамнаас 1,250.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг багаж, техник хэрэгслийн зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн “Нийтийн номын сан” нь 2021 онд нийт 146,631.6 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 8,840.1 мянган төгрөгийн 3 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна. Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгч ажиллалаа.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу холбогдох заалтыг зөрчөөд ажилласан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмж байхгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,706.5 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 166.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 8,840.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,699.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаагүй тул залруулга хийгдээгүй байна.

4.2 Төлбөрийн акт

1. Хууль, тогтоомжид заагдаагүй дотоод журмын дагуу олгосон 166.6 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшуулалд суутгал тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 АЛБАН ШААРДЛАГА

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хандиваар 12 хувь хүн, байгууллагаас 68 ширхэг 897.1 мянган төгрөгийн номыг үндсэн хөрөнгөд бүртгэж авсан, авлагын тооцоо нийлсэн акт 2,500.0 мянган төгрөг, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ болох 5,443.0 мянган төгрөгийн талаар бүрэн мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.5, 6.4.4, 6.4.8дахь заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хууль эрхийн үндэслэлгүйгээр Б.Аасүрэн, Ш.Отгоншагдар нарт сахилгын шийтгэл ногдуулсан тушаалыг хүчингүй болгосон

1.2. Өгсөн зөвлөмж:

Захиргааны ерөнхий тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.7, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн дотоод хяналтын журам боловсруулж, хэрэгжүүлэх

2. Татварын цахим баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүй

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал болон “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул татварын цахим бүртгэлийн системээр худалдан авалтыг хянаж ажиллах

3. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Эдийн засгийн ангилал зөрчиж нормын хувцас, зөөлөн эдлэл зардлаас 727.1 мянган төгрөгийн цэвэрлэгээний зардалд зарцуулсан

3.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", 2021 оны 190 дүгээр тушаал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймгийн Нийтийн номын сан	5	9,733.8			1	166.6	1	8,840.1	3	727.1